

Living the Lotus 5

Buddhism in Everyday Life

2026
VOL. 248



РКК, Чикаго салбар

Living the Lotus Vol. 248 (2026.05)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, ОУХ
Хаяг: Fumon Media Center, 2-7-1
Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Би юу хийж чадах вэ?

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Хамтдаа оршдог нь хүний орчлон

Хүмүүс бид дан ганцаараа бол хүчгүй бөгөөд өчүүхэн билээ. Хүн төрөлхтөн хэлж ярьж, багаж хэрэгсэл хэрэглэдэг болсноор эвлэлдэн нэгдэх гэсэн давуу талыг олсон. Тийм биш байсан бол байгалийн шалгаралд ялагдаж, амьд үлдэж чадахгүй байх байсан гэдэг. Хүн бол нийгмийн амьтан гэдэг нь ч гэсэн хүмүүс санал бодлоо солилцож, бие биенээ дэмжин хамтдаа сайхан амьдрахын төлөө дэвшилтэт нийгмийг бүтээн байгуулсан болохоор тэгж хэлдэг биз ээ. Би өмнө “Хүмүүс бид эвтэй амьдрах нь хүний төрөлхийн мөн чанар” гэж хэлж байсан ба амь насны үүсэл хөгжлийн түүхээс харсан ч гэсэн энэ ойлгомжтой.

Гэвч өнөө үед хувь хүний үзэл бодлыг чухалчилдаг болсноос тэр үү, хүний онцлог чанар болох санаа бодлоо хуваалцах, хүнтэй эвтэй байя гэсэн сэтгэлийг үгүйсгэх хүн ч байдаг болж. Энэ нь ганцаардал, цаашлаад ганцаардлын улмаас амиа хорлох гэсэн нийгмийн асуудлын шалтгаан болж буй хүн хүнээ үл тоох явдлыг бий болгож байна. Хүүхэд залуусын асуудал ч үүнтэй холбоотой ба Японы сүүлийн үеийн судалгаанаас үзвэл хүүхдийн тоо буурч байгаагийн дээр сургуулийн хүүхдийн амиа хорлолтын тоо өмнө байгаагүйгээр өсөж, арга хэмжээ авахгүй бол болохгүй хэмжээнд хүрээд байгаа ажээ.

Амь насны үүсэл гарал судлаач Накамүра Кэйко (1936~) арван хэдэн жилийн өмнө нэгэн нийтлэлдээ “Одоо би хамгийн ихээр хүүхдүүдэд л туслахыг хүсэж байна. Бага ангийн хүүхдүүд над руу «амьдармааргүй байна» гэсэн захиа илгээдэг” гэж бичиж байжээ. Тэгэхээр тэр үеэс л сургууль дээрээ ганцаардах, гэр бүлийн асуудлаас болоод сэтгэл нь гэмтэн «үхмээр байна» гэх хүүхдүүд байсан гэсэн үг юм.



Өдөр бүр хэрхэн амьдарч байгаагаа тунгаан бодох

Бид өөрсдөө зовлон үзсэн бол бусад хүн зовж шаналахад шууд л “энэ хүнд хэцүү байгаа даа” гэж сэтгэлийг нь ойлгодог. Харин тийм туршлага байхгүй бол зовлонг нь ойлгох байтугай ихэнхдээ тоодоггүй. Тийм болохоор үхмээр санагдах тийм хэцүү зовлон шаналалыг бол ойлгох хүн бүр ч цөөн биз.

Зэн урсгалын Доогэн багштан “Бурхны зам мөрд суралцана гэдэг өөрийгөө танин мэдэх болой” хэмээн сургасан байдаг. Хүн өөрөө өөрийгөө мэддэг гэж боддог боловч үнэндээ хүнийг байтугай өөрийгөө ч ойлгоогүй байдаг. Өөрийнхөө учрыг олоогүй байж хүний сэтгэлийг ойлгоно гэдэг үнэхээр хэцүү.

Тэгвэл хүүхэд залууст амьдрахад хэцүү санагдаж байгаа энэ нийгэмд бид тэдний сэтгэлийг ойлгож чадахгүй юу гэвэл тийм биш юм.

Сурган хүмүүжүүлэгч Мори Нобүзоо гуай (1896-1992) “Амьдрал хэчнээн хэцүү байлаа ч «амь нас»-ыг хүртэх шиг аз завшаан энэ орчлонд байхгүй. Үүнийг ойлгуулж ухааруулдаг зүйл бол жинхэнэ шашин” хэмээн онцлон хэлсэн байдаг бол өмнө өгүүлсэн Накамүра Кэйко гуай би хүүхдүүдэд “Чи яг одоо амьдарч байна гэдэг үнэхээр гайхамшигтай зүйл шүү дээ” гэж хэлэхийг хүсдэг гэжээ. Аль аль нь амь насны утга учрын талаар өгүүлсэн ба Накамүра гуай “Бид өөрийнхөө эх үндсийг хөөгөөд үзэх юм бол бүгд хоорондоо холбогдож 3.8 тэрбум жилийн өмнөх хүн төрөлхтний өвөг эцэг болох эс дээр тулж очно” гэж хэлээд, хүүхэд залуус “бүгд нэгэн бүхэл” гэдгийг ойлгох юм бол өөрийгөө хийгээд бусдыг хүндлэх сэтгэл, амьдрах эрч хүчтэй болно гэжээ.

Тэгвэл юуны түрүүнд бидний хийж чадах зүйл бол зовлонг хэрхэн хүлээж авч, яг одоо амьд яваадаа талархан хэрхэн амьдарч байгаагаа үлгэрлэн харуулах байж болох юм. Тэгээд зовлон бэрхшээлтэй тулгарсан хүний сэтгэлийн дуу хоолойг сонсож урам зориг өгөхөд л болно.

“Зовлон гэж юу вэ гэсэн асуултанд хүнээс тусгаарлах сэтгэл гэж хариулья”. Зэн урсгалын хувраг Рёокан (1758-1831) энэ үгээрээ хүн хүндээ туслахгүй, эв түнжингүй байх нь хамгийн том зовлон гэдгийг сургасан. Тиймээс бид өдөр бүр хүн хэрхэн амьдарвал зохилтойг тунгаан бодож, ойр тойрныхоо хүмүүсийн жижигхэн өөрчлөлтийг анзаарч “ямар нэг зүйл тохиолдоо юу” хэмээн санаа тавьдаг байх чухал. Ингэснээр бид бусдад тус хүргэж, хүүхэд залуусыг хүмүүжүүлж чадах юм.

«Косей» сэтгүүл, 5-р сарын дугаараас




Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp